

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Зундуй

Он сар өдөр, төрсөн газар	1916, Төв аймгийн Заамар сум
Үндсэн сүм хийд	Наймны хүрээ (Норовчоймпилон хийд)
Б.Ринченгийн сүм, хийдийн нэр	Наймны хүрээ

- Та Наймны хүрээний тухай ярьж өгөөч.

Наймны хүрээ гэдэг нь "Наймын хүрээ" гэсэн утгатай бөгөөд хойд зүг дэх Сэлэнгэ аймгаас Наймныхан овгийн найман өрх Заамар суманд суурьшснаар ийнхүү нэрлэгджээ. Наймныхны өөрийн хурал хурдаг уламжлал 18-р зууны үеэс тогтжээ.

- Их том хүрээ хийд байсан уу?

Нүүдэлчин малчид зуны улиралд голын эрэг хөндий даган бууж, өвөлдөө уул хангайруу буурь сэлгэдэг, харин хавар, намартаа Хүрээний эргэн тойронд бууж, хийдийн жасад хонь, ямаа, адуу өргөдөг байсан тул сүм хийдийн мал сүрэг, эд хөрөнгө арвижин нэмэгддэг байв.

- Хэдэн дугантай байв? Модон дуган байсан уу, тоосгон уу?

Хүрээ дөрвөн модон дугантай байсан бөгөөд бүгд дээвэр дээрээ алтан очир, алтан ганжиртай байсан нь Өвөрхангай дахь Эрдэнэзуу дахь сүмийн дээвэртэй адил байв.

- Ямар ямар дуган байсан бэ?

Эдгээр дөрвөн сүм нь Цогчин дуган; анхны Аймгийн дуган; хоёр дахь Аймгийн дуган болон Дарь Эхийн дуган байсан. Цогчин дуган нь хятад (манж) маягийн дээвэртэй хоёр давхар барилга байжээ. Сүмийн өмнө хоёр талдаа хүрд бүхий том бойпортой, сүмийн доод давхар нь уншлагын танхим, харин 2-р давхарт нь залуу лам нар нууцаар шагай харвадаг байсан гэдэг. Хоёр Аймгийн дуган болон Дахь эхийн дуган бүгд дөрвөлжин загварын барилгатай, Дарь эхийн дуган нь Цогчин дуганы чанх ард байжээ.

- Суварга байсан уу?

Эдгээр дөрвөн модон дуганаас гадна бусад барилгууд байсан ч харин суварга байхгүй, хашаагаар хүрээлэгдсэн, дөрвөн талдаа хүрдтэй байжээ.

- Дацан байсан уу?

Наймны Хүрээнд дацан буюу шашны сургууль байгаагүй тул ном сурах хүсэлтэй лам нар Сэлэнгэ аймаг дахь Бүргийн хуралд очиж ном сурдаг, аграмбын болон Гавжийн дамжаа барьж, сахил хүртдэг байжээ.

- Ямар хурал хурдаг байв?

Жил бүр томоохон ном судрыг хурах тусгай хурал ёслол болдог байсан.

- Ганжуур данжуур хурж байсан уу?

Ганжуур судрыг хоёр өдөр; Хангалын номыг нэг өдөр; Умын 16 ботийг нэг өдөр, Магтаалыг нэг өдөр; Ерөөлийн 10 ботийг нэг өдөр; Зулын 25 ботийг мөн хурдаг байжээ.

- Майдар эргэдэг байсан уу?

Майдар эргэх ёслолыг жил бүр тэмдэглэдэг, үүнд гурван лам ногоон морин толгойтой дөрвөн дугуйт тэрэг залж, лам нар шашин номын хөгжим зэмсэг дэлдэн ёслол үйлддэг, нутгийн ардууд цугларч, Майдар бурхан эх дэлхий дээр хурдан залрахын ерөөл айлтган ногоон морин тэргийг Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

даган мөргөл гороо үйлддэг байв. Зуны сүүл, намрын эхэн хайлган цагаар энэ ёслолыг үйлдвэх ба ард олон махан идээг цээрлэж, цагаан идээгээр дагнан буянд даган баясдаг байжээ. Энэ үе нь малын өөхөн тарга хайлдаг үе учир хайлган цаг хэмээдэг.

- Хэдэн ламтай байв?

1930-аад оны үед Найманы Хүрээнд 100 орчим лам шавилан суудаг байсны 40-50 нь өдөр бүр ном хурдаг байжээ. Лам нарын зарим хэсэг нь хийдийн лам нарын хороонд суурин амьдардаг, зарим нь өдөр бүр хийдэд ирдэг байв. Тухайлбал, хийдэд ном сурахаар бага залуу шавь нар хийдэд ирдэг байжээ. Лам нарын дотор гэр бүлтэй ганц хоёр л лам байсан.

- Том лам нар байсан уу?

1938 онд хоёр Гавж цолтой том лам баривчлагдан сураггүй болсны дараа эл хийдийг сүйтгэжээ. Бусад лам нар хийдийг орхиж, шар шувтлан энгийн хүмүүс болох ёстой байсны зэрэгцээ дараах 3-4 жилийн турш сумын даргад татвар торгууль төлөх ёстой болж байв.

- Сүм хэзээ хаагдсан бэ?

Сүм хийдийг бүхий л эд зүйлсийн хамтаар шатааж устгасан ба модон сүмийн туурь болон галаас үлдсэн бусад үлдэгдлийг хожим сумын төвд байшин барихад ашигласан байна.

- Та хийдэд хэдэн настай шавилж байв?

Би 1916 онд төрсөн, уг хийдэд долоон настайдаа орж, нийт 13 жил шавилсан байна. Улмаар 20 гаруй настайдаа хийдийг орхин, Ууцар нутаг буцсаны дараахан хийдийг сүйтгэсэн байна.

Ярилцсан: М.Жужа, Т.Кристина, 2004.